

Үзмэртэй хэрхэн харилцах заавар

Үзмэртэй харилцах журам

- Үзмэртэй харьцахын өмнө өөрийн хэрэглэж буй гоёл чимэглэлийг авах нь зүйтэй.
- Тухайн нөхцөлд зөвхөн нэг үзмэртэй харьцах
- Шаардлагагүй бол үзмэрийг хөдөлгөж, оролдохгүй байх
- Үзмэрийг зөөж байхдаа яарахгүй байх
- Үзмэрийг авахаасаа өмнө хааш нь зөөж, яаж байрлуулахаа төлөвлөх
- Үзмэрийг газар дээр шууд буюу жийргэвчгүй байрлуулахгүй байх
- Үзмэрийг байрлуулахад талбай цэвэр, ямар нэг саад тотгор болох зүйл байхгүй эсэхийг урьдчилан шалгах
- Аливаа зүйлийг цуглуулгын үзмэрийг түшүүлж тавихгүй байх

Үзмэрийг өргөх

- Үзмэрийг хоёр гараараа өргөх, хэрэв хоёр хүн өргөж байгаа бол хоюулаа зэрэг өргөж байгаа эсэхээ анхаарах
- Үзмэрийг өргөж зөөхийн өмнө гараараа уг зүйлийг дороос нь сайн барьсан эсэхийг анхаарч, тодорхой өндөрт үзмэрийг хавтгай талбайгаас, жишээ нь шалнаас дээш өргөсний дараа зөөх
- Үзмэрийг өргөж өмнө салдаг хэсгүүдийг тусад нь авч тавих
- Том, хүнд зүйлийг өргөхдөө нуруугаа бус, өвдгөө нугал

Үзмэртэй харьцах

- Үзмэрийг үргэлж анхааралтай барьж бай
- Өндөр биетийг нэг гараараа доороос нь, нөгөө гараараа хажуу талаас нь түшиж тогтвортой байдлаар өргөх
- Хавтгай үзмэрийг өргөхдөө гараа / магадгүй бугуйгаа/ доогуур нь оруулж аль болох жигд өргөх
- Үзмэрийн хэврэг хэсгүүдийн талаар урьдчилан мэдэж, тэр хэсгээс барихгүй байх. Жишээ нь амархан хугарч болох бариул гм.
- Овор том, хүнд, төвөгтэй үзмэртэй харьцахдаа туслалцаа дэм авах
- Үзмэрийг чирэхгүй байх
- Уран зургийг зөөхдөө хүрээ жаазны бат бөх хэсгээс нь барих, зотон даавууны аль нэг талд нь дарахаас болгоомжил. Зургийн жинг тэгш хэмээр өргөж, зургийн хэмжээ том бол хоёр талаас нь 2 хүн өргөх нь зүйтэй
- Үзмэртэй харьцахдаа түүний материалд тохирсон хөвөн бээлий өмсөх ба бээлий өмсөөгүй үедээ таны гар цэвэр, хуурай байгаа эсэхийг анхаар
 - Хэдий гар цэвэр байсан ч хүний гарын арьсан дээрх тос, хүчил нь металл эд зүйлд зэврэлт өгөх, түрхэцгүй керамик, цаас, уран зурагт өнгөний өөрчлөлт үүсгэх тул эдгээр материалтай харьцахдаа бээлий өмсөж байх
 - Хүний гарын тос, хүчил нь шил болон түрхэцтэй керамикт шууд нөлөөлөхгүй, тэдгээр нь гулгамхай байдаг тул түүгээр хийгдсэн

үзмэрийг унагаж гэмтээхгүйн үүднээс бээлий өмсөхгүй барих. Гэвч гарын тос, хүчил нь яваандаа нөлөөлж болзошгүй тул үзмэрийг байрлуулсны дараа хурууны хээг арчиж цэвэрлэх

- Жижиг үзмэрийг хол зайд зөөх бол тэдгээрийг хайрцаг, тавиурт байрлуулж, дотор нь хөдөлгөөнгүй байлгахын тулд хооронд нь зөөлөн, цэвэр зүйлээр жийргэвч хийх. Жийргэвч хийхгүй бол үзмэрүүд гэмтэх магадлалтай.
- Үзмэрийг хайрцаг, тавиурт байрлуулахдаа давхарлахгүй байх
- Үзмэрийг хол зайд тухайлбал, өрөөнөөс өрөөнд зөөж байгаа бол танд хаалга онгойлгож өгөх хүн хэрэгтэй.

Гамшгийн үед авах арга хэмжээний зөвлөмж

Цуглуулгад гамшгийн байдал нүүрлээд байгааг мэдмэгцээ та юу хийх шаардлагатай вэ.

Цуглуулгад гэмтэл учруулсан буюу учруулж болзошгүй ус алдах, хөгц үүсэх, аливаа халдлага, хортон шавьжны үүрлэлт, тоног төхөөрөмжийн гэмтэл зэрэг яаралтай арга хэмжээ авах шаардлагатай нөхцөл үүссэнийг илрүүлмэгц юу хийх хэрэгтэйг та энэхүү хуудсаас мэдэж авна.

Энэ зөвлөмжийг аливаа нөхцөлд харах боломжтой ил газарт байрлуулна уу!

Даруй авах арга хэмжээ

Цуглуулгын талаар яаралтай арга хэмжээ авах нөхцөл байдал бий болсныг мэдмэгц та:

- Зөв аюулгүй арга хэмжээ авахын тулд та дараах зүйлүүдийг анхааран тухайн нөхцөл байдалд дүгнэлт хийх. Үүнд:
 - Гамшгийн эх үүсвэр
 - Цуглуулга гамшигт өртсөн эсэх
 - Тухайн талбай аюулгүй эсэх
- Холбогдох хүмүүст тухайн байдлыг яаралтай мэдэгд. Үүнд:
 - Хамгаалалтын ажилтнууд
 - Гамшгаас хамгаалах албаны зохицуулагч
 - Захирал буюу дэд захирал
 - Сан хөмрөгчид, бүртгэл мэдээллийн санч нар
 - Эрдэм шинжилгээний ажилтнууд

Цуглуулгыг нүүлгэн шилжүүлэх

Үзмэр, эд өлгийн зүйлийн гэмтлийг нэмэгдүүлэхгүй байх, мөн аюулгүй байдлыг хангах үүднээс захирал болон дэд захирлын шууд зааварчилгаа, зөвшөөрөлгүйгээр цуглуулгыг музей дотор болон музейгээс **нүүлгэн шилжүүлэхгүй** байх.

Хэрвээ цуглуулгад аюултай бол, цуглуулгыг хамгаалах шуурхай шуурхай арга хэмжээг богино хугацааны дотор авах.

Богино хугацааны дотор авах арга хэмжээ

Гамшигт өртсөн болон гамшиг нүүрлээд байгаа цуглуулгыг хамгаалахдаа:

- Осол аюул болж байгаа эх үүсвэрийг боломжтой газарт нь зогсоох
- Гэмтсэн үзмэрт хүрч, хөдөлгөөнд оруулахгүй байх
- Цуглуулгад нөлөөлж байгаа ус алдалт, тоос шороо зэргээс сэргийлэхийн тулд:
 - Цуглуулгыг гялгар уут зэрэг бүтээлгээр бүтээх
 - Хувин, саваар усыг утгаж авах, алчуур, шингээгч материалаар усыг шингээх.

Юу хийж байгаагаа ухамсарлаж байх – санаачлагатай ажиллах

Д.Бумаа Ph.D

МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга